



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 дүгээр сарын 28 өдөр

Дугаар 05

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын V хуралдааныг 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 17:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 28 гишүүд оролцохоос 26 гишүүнтэй 92.8% ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа үүссэн нөхцөл байдлын талаарх шинэ мэдээллийн танилцуулах;
2. Баянхошуу хилийн боомтод үүссэн нөхцөл байдлын талаарх Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяагийн гаргасан санал;

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:


Аймгийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 03 дугаар хуралдаанаас гарсан шийдвэрийг хэвээр байлгахыг аймгийн Онцгой комиссын нийт гишүүдийн 95 хувийн саналаар шийдвэрлэв;


Аймгийн Засаг даргын Тамгын газрын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүхэд

1. Хөлөнбуйр аймаг, Манжуур хот, Шинэ барга баруун хошуу, Шинэ барга зүүн хошуу, Шилийн гол аймгуудын удирдлагуудад үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээлэл ирүүлж хамтран ажиллах тухай албан бичгийн төслийг боловсруулж танилцуулахыг;

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Бат-Эрдэнэд:

1. Петроцайна дачин тамсаг ХХКомпани болон тээвэрлэлтийн компаниудын удирдлагуудад Монгол жолооч нарын хүсэлтийн дагуу хилийн боомтоор тээвэрлэлтийг түр хугацаагаар зогсоох тухай албан бичгийг боловсруулж танилцуулахыг;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН
ОРЛОГЧ ДАРГА  Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА

